

## **ADHD**

### **Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг**

1

This module deals with inclusive education for students with attention deficit hyperactivity disorder (ADHD).

Энэхүү хичээлээр анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчдыг тэгш хамруулан сургах асуудлын талаар авч үзнэ.

2

Teaching children with this condition can be a real challenge.

Ийм нөхцөл байдалтай хүүхэдтэй ажиллана гэдэг үнэхээр хэцүү байдаг.

3

This tutorial consists of 3 parts:

Энэ хичээл нь дараах 3 хэсгээс бүрдэнэ.

4

An introduction,

1. Удиртгал хэсэг

5

the main symptoms of ADHD,

2. Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн илрэх гол шинж тэмдэгүүд,

6

and typical situations that can often occur during lessons and ways of coping with them at school.

3. хичээлийн үеэр түгээмэл тохиолдох хүндрэлтэй нөхцөл байдлууд, тэдгээрийг сургууль дээр даван туулах арга замууд.

7

Let us start with the introduction.

Ингээд удиртгал хэсгээс эхлэе.

8

What exactly is ADHD?

Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх /АДХХЭ/ эмгэг гэж яг юу вэ?

9

ADHD is the most prevalent behavioral disorder among children and adolescents,

Энэ бол өсвөр насны хүүхдүүдийн дунд

10

especially among school-age students.

тэр дундаа сургуулийн насны сурагчдын дунд хамгийн түгээмэл тохиолддог зан авирын гажуудал юм.

11

It is a persistent and chronic pattern of inattention and/or hyperactivity-impulsivity

Энэ нь сургууль дээр болон гэртээ, мөн олон нийтийн дунд биеэ авч явахад саад учруулдаг

12

that interferes with functioning at school, at home, and in the community.

байнга анхаарал сулрах болон хөдөлгөөний хэт идэвжилттэй болох эмгэг юм.

13

Often at school, teachers or parents have the following false opinions about ADHD:

Ихэвчлэн сургуулийн орчинд болон багш нар, эцэг эхчүүд энэ талаар дараах буруу ойлголттой байдаг:

14

The first false opinion is that ADHD does not exist.

Эхнийх нь АДХХЭ гэх зүйл бодит байдал дээр байдаггүй гэж үздэг.

15

ADHD is a real medical condition.

Харин энэ нь бодитой эрүүл мэндийн асуудал юм.

16

Research shows that ADHD is hereditary.

Судлаачид энэ төрлийн эмгэгийг удамшлийн гаралтай гэж үзжээ.

17

Moreover, studies show differences in brain development between children with ADHD and children who don't have it.

Түүнчлэн ийм төрлийн эмгэгтэй болон эмгэггүй хүүхдүүдийн тархины хөгжлийн ялгааг судалсан байна.

18

The second false opinion is that ADHD is a problem of laziness.

Мөн бас нэг буруу ойлголт бол анхаарлын дутмагшил, хөдөлгөөний хэт идэвхижилт бол залхуурлаас үүдэж буй асуудал гэж үздэг явдал юм.

19

ADHD isn't a problem of motivation.

Гэвч АДХХЭ бол залхуурсан болон санаачлагагүй болсоноос үүдсэн асуудал огт биш.

20

Telling people with ADHD to "just focus" or "try better" is like asking someone who's nearsighted to just see farther.

АДХХЭ-тэй хүмүүсд "анхааралтай хий" эсвэл "илүү сайн оролдоод үз" гэх мэт үгс хэлэх нь ойрын хараа муутай хүнээс хол байгаа зүйлийг асууж байгаатай л адил явдал юм.

21

The reason they struggle with attention has nothing to do with attitude.

Тэдний анхаарлаа төвлөрүүлэх гэж тэмцэх нь хандлагатай нь ямар ч хамаагүй юм.

22

The third false opinion is that all children with ADHD are hyperactive.

Гурав дахь буруу ойлголт бол АДХХЭ-тэй бүх хүүхдүүд бүгдээрээ хэт хөдөлгөөнтэй байдаг гэх ойлголт юм.

23

The stereotype of kids with ADHD is that they can't stop moving.

АДХХЭ-тэй хүүхдүүдийн нийтлэг хэв шинж бол тэд ямагт ямар нэг хөдөлгөөн хийж байдаг явдал юм.

24

But not all kids with ADHD have hyperactivity as a symptom.

Гэхдээ АДХХЭ-тэй бүх хүүхдүүдийн гол шинж тэмдэг нь хөдөлгөөний идэвхижилт гэж үзэж болохгүй.

25

One of the ADHD subtypes is that with a predominance of inattention.

АДХХЭ-ийн нэг дэд шинж тэмдэг бол анхаарал төвлөрөхгүй байх явдал юм.

26

It is more common in girls and often goes untreated because such a child is "polite"

Энэ төрлийн шинж тэмдэг гол төлөв охидод илрэх бөгөөд ерөнхийдөө эмчлэгдэлгүй үлддэг.

27

and does not disturb the environment.

Учир нь охин хүүхэд "ээлдэг" ааш зантай байдаг, бас орчин тойрноо нэг их үймүүлээд байдаггүй учир ажиглагддаггүй байна.

28

The label "capable but lazy" is often synonymous with students with ADHD.

"Авьястай боловч залхуу" байх тохиолдол бол АДХХЭ-тэй нэг ижил ойлголт юм.

29

The fourth false opinion is that ADHD is the scientific name for naughtiness

Дөрөв дэх ташаа ойлголт бол АДХХЭ нь сахилгагүй байдлын шинжлэх ухааны нэр нь гэж үзэх явдал бөгөөд

30

and that ADHD is the result of poor parenting.

эцэг, эхчүүд хүүхдүүддээ муу анхаарал хандуулснаас үүдсэн гэх нь бий.

31

ADHD is caused by neurodevelopmental differences in the brain,

АДХХЭ нь тархины мэдрэлийн хөгжлийн ялгаатай байдлаас үүдсэн болохоос

32

эцэг, эхчүүд хүүхдүүддээ муу анхаарал тавьсанаас үүдсэн асуудал биш юм.

33

But if adults do not support the child with ADHD, or punish the child for symptoms,

Гэхдээ хэрэв насанд хүрэгчид АДХХЭ-тэй хүүхдээ анхаарахгүй, нэг бол тухайн эмгэгтэй байсных нь төлөө шийтгэвэл

34

then it can interfere with the functioning of a child and form a vicious circle:

хүүхдийн биеэ авч явах байдалд саад болж хандлагыг нь буруу тийш нь эргүүлдэг:

35

punishing for ADHD symptoms leads to weakening self-esteem,

АДХХЭ-ийн шинж тэмдгүүдтэй байсных нь төлөө шийтгэх нь хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулж

36

and finally to the secondary intensification of disordered behaviors.

эцэст нь зан ааш эвдрэх хоёрдогч хүчин зүйлс эрчимжихэд хүргэдэг.

37

What are the main symptoms of ADHD?

АДХХЭ-ийн гол шинж тэмдэгүүд ямар байдаг вэ?

38

ADHD has two broad symptom clusters.

АДХХЭ-ийн хоёр төрлийн шинж тэмдэг байдаг.

39

The first is inattention, which includes behaviors such as being easily disorganized, lost, and forgetful.

Эхнийх нь эмх замбараагүй, зохион байгуулалтгүй, мартамхай, хайнга гэх зэрэг зан байдлаар илэрдэг анхаарал муутай байх үзэгдэл юм.

40

The second is hyperactivity and impulsivity, which means behaviors like reacting without reflection,

Удаах нь маш их хөдөлгөөнтэй байх үзэгдэл бөгөөд ямар нэг бодож төлөвлөсөн зүйлгүй аливаа үйлдэл хийх,

41

having difficulty sitting still, or having difficulty waiting for a turn.

удаан сууж юм хийж чадахгүй байх, эсвэл ямар нэг зүйлд өөрийн ээлж ирэхийг хүлээж тэвчихгүй байх гэх мэт зан байдлаар илэрдэг.

42

The student with concentration difficulties  
Анхаарлын төвлөрлийн бэрхшээлтэй суралцагч нь

43

often fails to give close attention to details,

гол төлөв юмсын нарын ширийн зүйлсийг ойлгох чадамжгүй байдаг бөгөөд

44

makes careless mistakes,

анхаарал суларснаас үүдэн алдаа гаргаж,

45

has trouble holding attention to tasks or play activities,

даалгавар гүйцэтгэх болон дүрийн тоглолт хийх гэх мэт үйл ажиллагаа явуулах чадваргүй байх,

46

does not seem to listen when spoken to directly,

шууд харилцахад ойшоохгүй байх,

47

does not follow through on instruction,

дасгалын тайлбарыг ойлгохгүй байх,

48

fails to finish schoolwork,

гэрийн даалгавраа хийж дуусгаж чадахгүй байх,

49

has difficulties organizing tasks and activities,

өгөгдсөн даалгавар, үйл ажиллагаагаа зохицуулахад хүндрэлтэй байх,

50

avoids, dislikes, or is reluctant to do tasks that require mental effort over a long period

шүүмжлэлд дургүй буюу урт хугацаанд оюун ухааны чадамж шаардсан даалгавар хийх дургүй байх,

51

and loses things necessary for tasks and activities.

даалгавар болон бусад зүйлсэд хэрэгтэй зүйлсийг орхигдуулах, хаяж гээх гэх мэт байдал гаргадаг.

52

To sum up, the student with inattention symptoms is easily distracted and forgetful in daily activities.

Эцэст нь хэлэхэд анхаарлын сулралтай суралцагчийн анхаарал маш амархан сарнидаг бөгөөд өдөр тутам хийдэг үйлдлээ мартаж нь элбэг байдаг.

53

Hyperactive and impulsive students are often physically restless.

Хэт хөдөлгөөнтэй суралцагчид нь бие махбодийн хувьд ихэнхдээ амар тайван биш байдаг.

54

Fidget with, or tap hands or feet, or squirm in their seat.

Ийм хүүхэд түгшсэн байдалтай, гараараа буюу хөлөөрөө элдэв юм тогших, эсвэл суудал дээрээ хавчиганаж байдаг.

55

Leave their seat in situations when teacher expects remaining seated.

Багш нь сууж байгаараа гэхэд босоод явчихдаг.

56

Runs about or climbs in situations where it is not appropriate.

Тохиромжтой бус үед ийш тийш гүйж эсвэл юмруу авирна.

57

Is unable to play or take part in leisure activities quietly.

Хичээлийн бус цагаар хийх үйл ажиллагаанд тоглоом тоглох, бусад төрлийн ажилд чимээгүй оролцох чадваргүй байдаг.

58

Is "on the go" acting as if "driven by a motor".

Ийм хүүхэд "мотортой" юм шиг л байдаг.

59

Talks excessively.

Мөн дэндүү их ярьдаг.

60

Blurts out an answer before a question is completed.

Асуулт асууж дуусаагүй байхад л хариулна.

61

Has trouble waiting for a turn.

Ээлжээ хүлээх чадваргүй.

62

Such sudden and thoughtless behaviors frequently interrupt others.

Гэнэт сонин зан ааш гаргаж бусдад саад хийдэг.

63

The symptoms of ADHD pose a great educational challenge.

АДХХЭ-ийн иймэрхүү шинжүүд нь боловсорлын том сорилт, бэрхшээлийг үүсгэж байна.

64

The method of teaching must be adapted to the student's abilities.

Ийм тохиолдолд сургалтын арга нь суралцагчдын чадварт нийцсэн байх ёстой.

65

Otherwise, children may manifest serious additional educational problems,

Эс бөгөөс суралцагч сургалтын үеэр бусад төрлийн асуудлуудыг үүсгэж,

66

and even disrupt the lessons of the whole class.

хичээлийн үеэр ангийг тэр чигт нь үймүүлдэг.

67



Therefore in inclusive education, it is important to support them to learn, play,

Тиймээс тэгш хамруулах боловсролын үүднээс тэднийг сурч, тоглож,

68

contribute and participate in all social aspects of life at school.

сургуулийн амьдралын бүхий л олон нийтийн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах, оролцож сургах нь чухал байдаг.

69

We will now describe four areas of functioning, in which it is crucial to assist students with ADHD:

Одоо бид АДХХЭ-тэй хүүхдэд туслах шаардлагатай үйл ажиллагааны дөрвөн чиглэлийг авч үзье:

70

support focus,

анхаарлын төвлөрлийг дэмжих,

71

support proper behaviors,

зөв зан үйлийг нь дэмжих,

72

support social interactions among all students in class

анги доторх нийт хүүхдийн дунд нийгмийн харилцааг нь дэмжих,

73

and support positive self esteem of students.

өөрийгөө эерэгээр үнэлэх үнэлэмжийг дэмжих зэрэг юм.

74

When inattention is the main symptom, it is important to avoid the distraction of the student with ADHD.

Хэрэв ийм эмгэгтэй хүүхэд анхаарлын төвлөрөлтгүй байх гол шинж тэмдэгтэй бол анхаархлыг нь сарниулахгүй байх нь нэн чухал.

75

There are many ways of supporting a child's focus.

Хүүхдийн анхаарлын төвлөрлийг дэмжих олон арга замууд бий.

76

Firstly, it is necessary to limit the number of stimuli in the classroom.

Эхнийх нь, анги доторхи анхаарал сарнилт өдөөх зүйлсийг хязгаарлах.

77

The range of distractors should be attuned to the students' ability to process information from the environment.

Суралцагчийг гадна орчны мэдээллийг боловсруулах чадвартай байлгах үүднээс анхаарал сарниулах зүйлсийг хязгаарлах нь зүйтэй.

78

If the student is easily distracted by peers' activities,

Суралцагч үе тэнгийнхнийхээ үйл ажиллагаанд амархан сатаардаг бол

79

it can be helpful to choose the right place in the classroom:

анги дотор суулгах байрлалыг зөв сонгох нь чухал юм.

80

away from the window, close to the teacher, and with a calm student.

Жишээ нь, цонхноос хол, багшид ойрхон, тайван даруухан хүүхэдтэй суулгах.

81

Providing short breaks between tasks can also be very helpful to stay focused.

Даалгавруудын дундуур богино хэмжээний завсарлага авч байх нь анхаарлаа үргэлжлүүлэн төвлөрүүлэхэд нэн чухал ач холбогдолтой.

82

However, a student with ADHD takes boredom very badly.

Хэдий тийм ч АДХХЭ-тэй суралцагч уйтгарлахаараа маш тааруухан байдалтай болдог.

83

Because of that, the most effective method of support attention

Иймээс анхаарал төвлөрүүлэх хамгийн үр дүнтэй арга нь

84

is to use all kinds of instruments to interest the child with the educational material.

сургалтын материалаар хүүхдийн сонирхолыг татах бүх төрлийн арга хэрэгслийг ашиглах юм.

85

These may include: using interactive teaching methods,

Үүнд: сургалтын интерактив аргыг ашиглах,

86

involving a student in lesson presentation,

хичээлийг танилцуулахад хүүхдийг татан оролцуулах,

87

telling a joke at the end of a lesson,

хичээлийн төгсгөлд хөгжилтэй зүйлс ярих,

88

using various tools like audiobooks, computer programs, or phone applications.

аудио ном, компьютерийн програм, утасны аппликейшн зэрэг олон хэрэгсэл ашиглах байж болно.

89

The teacher can also ask the student to plan the following activities.

Мөн багш сурагчдаас дараах үйл ажиллагааг төлөвлөхийг санал болгож болно.

90

This can develop the ability to pay attention to task organizing.

Энэ нь даалгаврыг зохион байгуулахад анхаарах чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой.

91

The teacher can ask: What are you going to do now?

Багш: Чи одоо юу хийх гэж байна вэ? гэж асууж болно.

92

Perhaps in the future, the same student will ask himself: What should I do?

Магадгүй ирээдүйд тухайн суралцагч өөрөөсөө "Би юу хийх ёстой вэ?" гэх асуултыг асуух байх.

93

Teachers should find out what are the so-called Islands of Competence.

Багш нар "Чадамжийн арал" гэж юу байдгийг олж мэдэх хэрэгтэй.

94

These are the areas of the student's functioning, which are a source of personal satisfaction.

Эдгээр нь суралцагчдын хувийн сэтгэл ханамжийн эх үүсвэр болсон үйл ажиллагааны талбар хүрээ юм.

95

Examples are: using the student's area of interest in reading exercises,

Жишээ нь, суралцагчийн унших дасгал хийх сонирхол дээр тулгуурлан ажиллах,

96

preparation of presentations about interesting topics,

сонирхдог сэдвээр нь илтгэл презентаци хийлгэх,

97

using hip-hop songs to learn foreign languages,

хип - хоп дуу ашиглан гадаад хэл сургах,

98

carrying out a physical education warm-up.

биеийн тамирын дасгал хийлгэх гэх мэт.

99

How to support focus and how to regain the ability to concentrate?

Анхаарлын төвлөрөлтийг хэрхэн дэмжиж, төвлөрөх чадварыг сайжруулах вэ?

100

The teacher can focus the already distracted attention of the student by frequent recalling,

Багш суралцагчийн сарнисан анхаарлыг ахин дахин байнга дуудах,

101

pointing, short comments, encouraging the student with a private signal,

сануулах, товч тайлбар хийх, хувийн дохио зангаа хэрэглэх,

102

providing something tactile and quiet to support focus.

анхаарлыг нь татаж төвлөрүүлэх ямар нэгэн мэдрэгдэхүйц чимээгүй зүйлс ашиглах замаар сарнисан анхаарлыг нь татаж болно.

103

How to support behaviors?

Зан аашийг нь яаж дэмжин төлөвшүүлэх вэ?

104

The teacher can develop a system of rules, target behaviors and reward and verbal praise.

Багш зан байдлаа зөв авч явах талаар олон төрлийн дүрэм журам гаргаж, сайшаалын үгээр урамшуулж байх ёстой.

105

Students with ADHD require clear and consistent rules, precise time management,

АДХХЭ-тэй суралцагчид нь ойлгомжтой, тодорхой дүрэм журам, цагийн нарийн зохион байгуулалт,

106

clear formulation of expectations they have to meet,

мэдэхийг хүссэн зүйл, хүлээсэн үр дүнг нь тодорхой томъёолох,

107

and have to know and expected consequences in correcting their behavior.

зан аашийг нь засаж төлөвшүүлснээр гарах үр дүн зэргийг тодорхой байлгахыг шаарддаг.

108

The teacher can ignore impulsive and hyperactive behavior that does not disrupt teaching,

Хичээл үймүүлэхээргүй бол эрчимтэй, хэт идэвхитэй зан байдлыг багш ойшоож үзэхгүй байж болох ба

109

anticipate and prevent the possibility of impulsive and hyperactive behavior occurring

ийм байдлыг урьдаас анзаарч, сэргийлэх,

110

and recall frequently the rules system in place, especially when undesirable behavior occurs.

ялангуяа таагүй ааш авир гаргахаар болж ирвэл мөрдөх ёстой дүрэм журмаа ахин тайлбарлаж өгөх хэрэгтэй.

111

Target behaviors are the appropriate concrete behaviors the teacher wants the student to practice.

Зорилгот зан үйл гэдэг нь багшийн сурагчаас хийж заншихыг хүсч буй тодорхой зохимжот зан үйл юм.

112

They are listed in a simple and positive way.

Ийм зан байдлыг энгийн, эерэг байдлаар жагсаан бичнэ.

113

For example, rather than "No running in the halls" the teacher might simply use "Walk" as a target behavior.

Тухайлбал, "Ангид гүйхгүй байх" гэхээс илүү "Алхаарай" гэдгийг зорилгот зан үйл болгон ашиглаж болно.

114

The behaviors will vary depending on the student's abilities and expectations.

Зан байдал нь суралцагчийн чадвар, хүсэл тэмүүллээс хамааран өөр өөр байдаг.

115

Some students may need a system set up for one behavior,

Зарим суралцагчид нэг зан байдалд нь тохирсон бүтэн тогтолцоо хэрэгтэй бол

116

while others may have a checklist of things they are working on throughout the day.

бусдад нь тухайн өдөрт хийх зүйлсээ тэмдэглэдэг жагсаалт хэрэгтэй байж болох юм.

117

It is important that the target behavior is clearly established.

Зорилтот зан байдлыг маш тодорхой тогтоох нь чухал.

118

It is disadvantageous to reward the student's random behavior.

Суралцагчийн санамсаргүй байдлаар хийсэн үйлдлийг урамшуулах нь зохистой зүйл биш.

119

The following list includes some examples of target behaviors.

Дараах жагсаалтад зорилтот зан байдлын зарим жишээг оруулав.

120

Turn work in on time.

Ажлаа цагт нь хүлээлгэж өгөөрөй.

121

Complete work.

Ажлаа дуусгаарай.

122

Raise your hand.

Гараа өргөөрөй.

123

Follow directions.

Зааврыг дагаарай гэх мэт.

124

The teacher should try to always provide a reward for a student with ADHD.

Багш АДХХЭ-тэй хүүхдийг үргэлж урамшуулж байх хэрэгтэй.

125

This should be an attractive reward to the student,

Урамшуулал нь суралцагчийн хувьд анхаарал татахуйц,

126

a feasible to realize reward for the teacher,

багшийн хувьд хэрэгжүүлэх боломжтой байх ёстой бөгөөд,

127

the rewards system should be applied to the entire class,

урамжууллын тогтолцоо нь ангийг бүхэлд нь хамаарна,

128

the reward should be adjusted to the individual student,

эсвэл тухайн нэг суралцагчид зориулсан байх ба

129

the reward is given when the target behavior occurs.

зорилтот зан байдал илэрсэн үед урамшууллыг өгнө.

130

What can also be a reward?

Өөр ямар урамшуулал байж болох вэ?

131

Any small awards in the area of freedom from learning, granting the privilege for a short time and small material rewards.

Хичээлээс чөлөөлөх, богино хэмжээний давуу эрх олгох, эсвэл жижиг материаллаг шагнал өгөх гэх мэт байж болно.

132

Verbal praise is very simple and specific praise

Үгээр урамшуулах нь маш энгийн, тусгай урамшуулал болдог ба

133

which is delivered as soon as possible or even while the expected behavior is ongoing.

аль болох хурдан эсвэл хүлээгдэж буй зан байдал үргэлжилж байгаа үед ч хэлж болно.

134

"You finished your whole task, great job"

"Чи бүх даалгавраа хийж дуусгалаа, тун сайн ажиллаа".

135

"You waited for your turn, great!"



"Чи өөрийн ээлжээ хүлээж чадлаа, гайхалтай".

136

"I like the way you listen to others"

"Чамайг бусдыгаа сонсож чадаж байгаа чинь надад таалагдаж байна".

137

It includes the description of the behavior and name of the feature:

Энэ нь зан төлвийн тодорхойлолт, онцлогуудын нэрийг агуулдаг:

138

"Books on the bench - this is called preparation!"

"Сандал дээрх номнууд - энэ нь бэлтгэл гэсэн үг".

139

"You wrote down the topic - that's called accuracy!"

"Чи сэдвийг бичсэн - энэ нь нарийвчлал гэсэн үг".

140

The teacher supports social interactions and class integration.

Багш нь нийгмийн харилцаа болон ангийн нэгдмэл байдлыг дэмжинэ.

141

The teacher can create a set of rules with students that will govern everyday life in the classroom,

Багш нь суралцагчдын танхимын өдөр тутмын амьдралд мөрдөх дүрэм журмуудыг гаргана. Үүнд:

142

discuss and establish the rights of the students' team, суралцагчдын багийн эрхийг хэлэлцүүлэн тогтоох,

143

rules regarding respect and acceptance in everyday contacts,

өдөр тутмын харилцаанд хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх дүрэм журмыг гаргах,

144

and the range of tolerance towards different behaviors,

өөр өөр зан байдлыг тэсвэрлэх чадварын хүрээг тогтоох,

145

develop mutual understanding and trust,

харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх,

146

establish group rules that regulate conflict situations,

маргаантай нөхцөлийг зохицуулах ангийн дүрмүүдийг тогтоох,

147

organize group classes, aimed at getting to know each other among children,

хүүхдүүдийн дунд биесээ таньж мэдэх зорилгоор бүлгийн хичээлийг зохион байгуулах,

148

communicating, and creating opportunities for positive relationships,

ээрэг харилцааг бий болгох боломжийг бүрдүүлэх, харилцах,

149

organize class meetings with established rules aimed at considering problems currently occurring in the class,

ангид шинээр гарч буй асуудлуудын тухай хэлэлцэх үүднээс тогтсон дүрмийн дагуу ангийн хурал зохион байгуулах,

150

provide support to students who cannot cope with various school situations.

сургуулийн янз бүрийн орчин нөхцөлд дасан зохицох чадваргүй суралцагчдыг дэмжих зэрэг багтана.

151

The teacher can strengthen the position of a student with ADHD in a class team

Багш нь ангийн АДХХЭ-тэй хүүхдийн байр суурийг анги дотор бэхжүүлнэ;

152

and create opportunities for students with ADHD in the role of a classroom expert,

тэдэнд ангийн шинжээчийн үүргээр ажиллах боломжийг бүрдүүлнэ;

153

assign special responsibilities to the student in presence of a peer group,  
үе тэнгийн бүлгийн суралцагчдын дэргэд тусгай үүрэг хариуцлага хүлээлгэнэ;

154

create situations when students can accumulate positive social experiences,

суралцагчид нийгмийн эерэг дадлага, туршлага хуримтлуулах нөхцөл бүрдүүлнэ;

155

hold a group meeting about how peers can support the student with ADHD

АДХХЭ-тэй хүүхдүүдийг бусад суралцагчид хэрхэн дэмжих талаар уулзалт зохион байгуулна;

156

and discuss possible causes of improper behavior and ideas for supporting students with ADHD

зүй бус зан авир гаргах байж болох шалтгаануудыг болон АДХХЭ-тэй суралцагчдыг дэмжих сэдэл санаачлагуудыг хэлэлцэнэ;

157

while the student with ADHD gives suggestions for peer actions that could help correct improper behavior.

АДХХЭ-тэй суралцагч нь зохисгүй зан байдлыг засахад туслах үе тэнгийнхний хийж болох үйл ажиллагаануудыг санал болгоно.

158

How to support a positive self-image?

Өөрийнхөө эерэг дүр төрхийг бий болгох явдлыг хэрхэн дэмжих вэ?

159

The teacher engages in complimenting positive behavior and schoolwork,

Багш эерэг зан байдал, сургуулийн ажилд оролцож байгаа оролцоог магтах ба,

160

giving opportunity to act in a leadership role,

манлайлах үүрэг гүйцэтгэх боломж олгох,

161

building confidence as experts,

шинжээч мэргэжилтний хувьд өөртөө итгэх итгэлийг бий болгох,

162

allowing their peers to see the student with ADHD as successful,

ангийнханд нь АДХХЭ-тэй хүүхэд амжилттай байж болохыг харуулах,

163

providing regular opportunities for students with ADHD to demonstrate and utilize strengths and talents.

АДХХЭ-тэй суралцагчдад давуу тал, авьяас чадвараа харуулах, ашиглах боломжийг тогтмол олгох хэрэгтэй юм.

164

In summary.

Дүгнэж хэлэхэд:

165

Creating an educational environment friendly to students with ADHD can be guaranteed if their teacher

АДХХЭ-тэй суралцагчдад таатай сургалтын орчин бий болгох баталгаа нь хэрэв багш

166

understands their psychosocial situation at school,

сургуулийн орчинд нийгэм сэтгэл зүйн байдлыг нь ойлгож,

167

is aware of the need to support them,

тэднийг дэмжих хэрэгтэйгээ ухамсарлаж,

168

is open and empathetic,

нээлттэй, уян зөөлөн байж,

169

and can perceive and appreciate the achievements, abilities, and talents of the students.

суралцагчдын авьяас чадвар, ололт амжилтыг мэдэрч, үнэлж чадвал боломжтой болно.

170

It is vital for setting norms and standards, to allow social and educational functioning of students with ADHD in the school environment,

Сургуулийн орчинд АДХХЭ-тэй хүүхдүүдийн сургуулийн орчин дахь нийгэм, боловсролын үйл ажиллагааг хангахын зэрэгцээ

171

while at the same time respecting the safety regulations for the whole class.

нийт ангийн сурагчдын аюулгүй байдлын журмыг дагаж мөрдөх нь хэм хэмжээ, стандартыг тогтооход нэн чухал юм.

172

In practice that means matching the educational methods and forms of teaching

Энэ нь практик дээр боловсролын заах арга зүй, сургалтын хэлбэрүүдийг

173

to the actual abilities of the students with ADHD and realizing their full potential.

АДХХЭ-тэй хүүхдүүдийн бодит чадвартай холбох, тэдний бүрэн чадамжийг ойлгож хүлээн зөвшөөрөх гэсэн үг юм.